



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

20 дд оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/25

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар журам, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын А/03 дугаар журмуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Багшийн хөгжлийн төвийн барилга (Ховд, Жаргалант сум)-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---------------|--------------|---|
| Дарга: | Н.Ганзориг | - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга |
| Гишүүдэд: | Д.Ариунбилэг | - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга |
| | Ж.Пүрэв-Очир | - Төрийн бус байгууллагын төлөөлөл |
| | Б.Балжинням | - Иргэний төлөөлөл |
| Нарийн бичиг: | Э.Цолмон | - Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн |

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Н.Ганзориг)-д даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Э.Цолмон)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД